



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 10 сарын 5 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад нэр дурдсан хүмүүсийг 2006-2007 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуульд Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Ө.ЭНХТҮВШИН

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2006 оны .10 дугаар сарын .05-ны өдрийн
338. дугаар тушаалын хавсралт

2006-2007 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны
их сургуульд суралцах хүмүүс

| № | Овог нэр | Сургууль | Мэргэжил | Түвшин | Сурах жил | Захиалагч байгууллага |
|---|--------------------------|--|----------------------------|---------|-----------|-----------------------|
| 1 | Алтангэрэл Лхамсэржид | АНУ-ын Калифорнийн Улсын их сургууль | Барилгын менежмент | Магистр | 2 | БХБЯ |
| 2 | Самбуу Отгонсүрэн | АНУ-ын Стрээр их- сургууль | Бизнесийн удирдлага | Магистр | 2 | ҮХЯ |
| 3 | Насанжаргал Отгонболд | АНУ-ын Калифорнийн Олон улсын их сургууль | Олон улсын худалдаа, | Магистр | 2 | ХХААЯ |
| 4 | Бат-Эрдэнэ Энэрэлт | АНУ-ын Ютагийн их сургууль | Хууль | Магистр | 2 | УИХТГ |
| 5 | Бат-Эрдэнэ Цэндсүрэн | АНУ-ын Де Врай их сургууль | Хүний нөөцийн менежмент | Магистр | 2 | УИХТГ |

*Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2006 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн
338 дугаар тушаалын хавсралт*